

БАТЛАВ:

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАР ОЙН ГАЗРЫН ДАРГА**

Б.ОЮУНСАНАА

**ОЙ, МОДНЫ САЛБАРЫН 100 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД БАРИМТАТ КИНО ХИЙХ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Зорилго	Монгол улсад ойн салбар үүсэж хөгжсөн 100 жилийн түүхэнд бичигдсэн онцгой үйл явдал тохиож байна. Үүнтэй холбоотойгоор өнгөрсөн 100 жилийн түүхэнд бичигдсэн онцгой үйл явдал, салбартаа нэрээ мөнхөлсөн ахмадууд, хөгжлийн үе шат бүхэнд онцгой үүрэг гүйцэтгэж гар бие оролцож байгаа үе үеийн ойчдын алдрыг, цаашлаад төр, засгийн бодлого шийдвэртэй холбоотойгоор хэрхэн хөгжиж ирсэн он жилүүд болон өнөөгийн байдлыг баримтжуулан дэлгэцийн бүтээл болгон түүхэнд үлдээх нь энэхүү баримтат киноны гол зорилго болно
Үндэслэл	Ардын засгийн газрын 1924 оны 09 дүгээр сард хуралдсан 39 дүгээр хурлаар Аж ахуйн явдлын яамыг 6 хэлтэстэйгээр байгуулж, түүний “Ой, модны хэлтэс”-т ой, мод, ан, амьтныг хамгаалах, зохистой ашиглах асуудлыг хариуцуулж, улмаар Аж ахуйн явдлын яамны сайдын 1924 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар тушаалаар уг хэлтсийн харьяанд Улаанбаатар хот болон Ерөөгийн эх Ходоод, Дорнодын Онон харуул, Хөвсгөл аймгийн Хатгалд анхны 4 ойн анги байгуулах шийдвэр гаргаснаар Монгол улсад орчин цагийн ой, модны салбар үүсэн байгуулагдах үндэс суурийг тавьсан бөгөөд эдүгээ энэ салбар 100 жилийн ойтой золгож байна.
Хугацаа	Гэрээний хугацаа 8 сар байх ба судалгааны ажлын эцсийн тайланг Захиалагчид хүлээлгэн өгснөөр гэрээ дуусгавар болно.
Баримтат киноны агуулга	<p>Ойн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан баримтат кино нь үндсэн 3 агуулга буюу бүлгээс бүрдэнэ. Мөн өвөл, зун, хавар, намар гээд Монгол орны ойн бүхий л хэв шинжийг харуулах, ойн салбарт хамааралтай бүх газруудыг багтааж дөрвөн улирлын онцлог, шинж чанарыг харуулах зураг авалт хийгдэнэ.</p> <p>I бүлэг: Монгол орны ойн нөхөн сэргээлт, ойжуулалт II бүлэг: Монгол орны ойн аж ахуй, ашиглалт, дагалт баялаг III бүлэг: “ГЭРБУМ МОД”- үндэсний хөдөлгөөн</p> <ol style="list-style-type: none">1. Ой, модны салбарын түүхэн замналыг уран сайхны өндөр түвшинд харуулах2. Түүхэн зохиол, дэс дараалал агуулга (1924 оноос өнөөг хүртэлх)3. Ой, модны салбарын одоогийн байдал, хөгжлийн явцыг (түүхэн хугацааг) үечлэн тоон мэдээлэл, ололт амжилт, төр засгийн бодлого, үйл ажиллагаанд тулгуурлан өгүүлэх, компьютер графикаар харуулах

	<p>4. Кинонд дараах агуулгуудыг оруулсан байх</p> <ol style="list-style-type: none"> a. Үр, тарьц суулгацын нөөцийн бүрдүүлэлт, Ойжуулалт, ой хамгааллын чиглэлд гарсан хөгжил, дэвшил b. Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийн хөгжил, дэвшил c. Ойн шинжлэх ухаан, гадаад хамтын ажиллагааны хөгжил дэвшил d. Хүний нөөц, боловсон хүчний хангамж, бүрдүүлэлт e. Засгийн газраас ой, модны талаар баримталж буй бодлого, цаашдын зорилт <p>5. Ой, модны салбарыг иргэд олон нийтэд сурталчлан таниулах зорилго агуулах</p> <p>6. Эх хувь, ашигласан материалын эх сурвалж, түүхэн материал, архивын судалгаатай байх</p> <p>7. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, их дээд сургууль, судлаач эрдэмтэд болон салбарын үе үеийн төлөөллийн санал бодлыг тусгах</p> <p>8. Киноны үндсэн хэл нь Монгол хэлээр байх бөгөөд Англи хадмал хэлтэй</p>
Ажил гүйцэтгэх үе шатууд	<p>Баримтат кино бүтээх үе шат 3 хэсэгт хуваагдана.</p> <p>1 дэх үе <i>шат</i>-Зохиол бичиж, дүр жүжигчид сонгох</p> <p>2 дахь үе <i>шат</i>-Зураг авалт, ярилцлага хийх</p> <p>3 дахь үе <i>шат</i>-Монтаж хийгээд хүлээлгэж өгөх</p>
Хамрах хүрээ	<p>Техникийн тодорхойлолтод дурдсан баримтат, агуулгын дагуу киноны дүр, гол үйл явдлуудыг тусгасан хураангуй зохиол буюу синопсисыг хоёроос илүүгүй хуудсанд багтаан бичиж тендерийн хамт ирүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> - Дүр оролцуулах шаардлагатай бол зохиолын дагуу дүр бүтээх жүжигчдийг захиалагчид танилцуулж, санал авах; - Киноны зураг авалт хийх газруудын байрлалыг тодорхойлж, хуваарийг захиалагчаар батлуулах; - Кино нь хамгийн багадаа нэг дуутай байх; - Зохиол, батлагдсан хуваарийн дагуу орчин үеийн дэвшилтэт технологиудыг ашиглан, дүрс, дууны өндөр чанартай иж бүрэн баримтат кино хийж захиалагчид хүлээлгэн өгөх; - Тендерийн хамт ирүүлсэн маркетингийн дэлгэрэнгүй төлөвлөгөөний дагуу киног бүтээх явцад олон нийтийн анхаарал, сонирхлыг татах маркетинг, сурталчилгааг хийж эхлэх;
Киноны хэмжээ	Баримтат кино нийт 75 минут байна.
Гүйцэтгэх хугацаа	6 сар
Тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> • Студи, нэгдэл, продакшн, компани нь Ой, модны салбарын 100 жилийн ойн баримтат кино бүтээх асуудлаар мэргэжлийн хамтарсан баг байгуулж оролцож болно • Байгаль орчин экологийн чиглэлээр төр болон хувийн хэвшил олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж дэлгэцийн бүтээл /КИНО, КОНТЕНТ/ гаргасан туршлагатай байх • Баг нь баримтат кино бүтээх мэргэжлийн боловсон хүчин (бие даасан студи)-тэй байх • Баримтат кино (реклам сурталчилгаа)-ны чиглэлээр (10-с доошгүй жил үйл ажиллагаа явуулсан) ажиллаж байсан туршлагатай байх • Студи, нэгдэл, продакшн, компани нь техник, тоног төхөөрөмжийн хувьд бүрэн хангагдсан байх. Телевизийн нэвтрүүлэг, баримтат кино бүтээх сүүлийн үеийн үзүүлэлт бүхий мэргэжлийн тоног, төхөөрөмж (зураг авалтад ашиглах дрон, лифт)-тэй байх • Баг нь ажил гүйцэтгэх санаа, төлөвлөгөөг урьдчилсан байдлаар боловсруулсан байх • Баримтат киног олон нийтэд хүргэх, телевизийн цацалтыг хариуцах

	боломжийг харгалзана.
Тайлангийн хуваарь	<ol style="list-style-type: none">1. Эхлэлийн тайлан: Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсанаас хойш 7 хоногийн дотор Захиалагчид хүргүүлнэ.2. Явцын тайлан: Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсанаас хойш 30 хоногийн дотор Захиалагчид хүргүүлнэ.3. Төслийн эцсийн тайлан: Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсанаас хойш 3 сарын дотор Захиалагчид хүргүүлнэ. Зөвлөх нь бүх тайлан, материалаа монгол хэл дээр бэлтгэн танилцуулна.

ТАЙЛАН ГАРГАХ ХУВААРЬ

Эцсийн тайлангийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 29-ны дотор ирүүлэх
Эцсийн тайланг зөвшөөрөх 2024 оны 11 дүгээр 30-нд хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх.

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Агуулга

Маягт 1: Тендер илгээх маягт

Маягт 2: Ижил төстэй ажил нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт